



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 1294

Мандалговь

“Анхан шатны хоршоо ба хадгаламж зээлийн хоршоог хөгжүүлэх” сургалт болон зөвлөх үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 81 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан” Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.” Анхан шатны хоршоо ба хадгаламж зээлийн хоршоог хөгжүүлэх сургалт болон зөвлөх үйлчилгээнд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх сургалтад шаардагдах 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

3. Хоршооны сургалтын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822111032